

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Аудитын ГЭРЧИЛГЭЭ	2
2.Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.27 № 06/613

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний урлагийн их театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний урлагийн их театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үндэсний урлагийн их театрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Үндэсний урлагийн их театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Үндэсний урлагийн их театрын захирал Г.Цоггэрэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн тухайн байгууллагын өөрийн онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдөх, дансны өглөг, авлага, төлбөр тооцоог хянан, баталгаажуулах, дотоод хяналт, санхүүгийн хариуцлагыг сайжруулах, нэмэлт орлогын төлөвлөгөөтэй ажиллах, хөрөнгийн бүртгэлтэй холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний урлагийн их театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний урлагийн их театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-оос 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Цэгцтөв богд аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Үндэсний урлагийн их театр 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Цэгцтөв богд аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 37 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үндэсний урлагийн их театрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол угсаатан, ястны утга соёлын өвийн сор дээжийг сурталчлах, судлах, сургах хийгээд үйлчлүүлэгч, харилцагч түншүүдийнхээ эрэлт шаардлагад нийцсэн орчин цагийн болон дэлхийн сонгомол бүтээлийг урлах чадавхи бүхий өндөр боловсролтой хамт олны бүрдлийг нэгтгэсэн мэргэжлийн урлагийн төв байхад оршино.

Үндэсний урлагийн их театр үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Урлаг соёлын үйлчилгээг мэргэжлийн өндөр төвшинд явуулах
- Ажилтны ур чадварыг дээшлүүлэх
- Сургалт сурталчилгаа явуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Нийгмийн даатгалын тухай хууль, ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Үндэсний урлагийн их театрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулж шинэчлэх шаардлагатай байна.

Үндэсний урлагийн их театр нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд интерактив программ хангамж ашигладаг байна.

Үндэсний урлагийн их театрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Үндэсний урлагийн их театрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,963,524.6 мянган төгрөгөөс тооцон 39,270.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 58,206.1 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд нийт зардлын дүн өмнөх оноос 946,779.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үндэсний урлагийн их театрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 241,219.20 мянган төгрөгөөр буюу 16.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	5,395.10	5,869.90	474.8
Урьдчилгаа			-
Бараа материал	1,160,599.60	1,429,637.50	269,037.90
Үндсэн хөрөнгө	1,383,667.50	1,450,332.60	66,665.10
Хуримтлагдсан элэгдэл	(1,050,886.70)	(1,145,845.40)	(94,958.70)
Нийт хөрөнгө	1,498,775.50	1,739,994.70	241,219.20
Өр төлбөр	3.30	-	(3.30)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,498,772.20	1,739,994.70	241,222.50
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,498,775.50	1,739,994.70	241,219.20

Авлага дансны үлдэгдэл өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлсөн 2,299.1 мянган төгрөг, гэрээт ажилтны цалингийн зөрүү 238.9 мянган төгрөгийн авлага үүссэнээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2005 онд үүссэн, он удаан жил болсон хувь хүнээс авах 3,331.8 мянган төгрөгийн авлага байна. Авлагыг барагдуулахаар хуулийн байгууллагад хандсан боловч холбогдох авлагын эзний хаяг тодорхой бус гэсэн шалтгааны улмаас барагдахгүй байх эрсдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тус байгууллага нь тайлант онд үндэсний түүхэн туульсын хөгжимт бүжгэн жүжиг буюу уран сэтгэмжит урлагийн бүтээл болох “Марко Поло” хэмээх XIII-XIV зууны үеийн эртний Монголын их эзэнт гүрний түүхэнд болж буй үйл явдлыг үлгэр домог уран сэтгэмжит туульс, “Цаг хугацааны машин буюу Алтан гэрэгэ” гурван бүлэг, арван гурван үзэгдэлтэй үндэсний түүхэн туульсын хөгжимт бүжгэн жүжиг, “Нүүдэлчдийн аялгуу III” ардын урлагийн шинэ бүтээлийг шинээр туурвисан, болон бусад үйл ажиллагаанд зориулан 135 тоглолтонд зориулагдсан уран бүтээлчдийн хувцас хэрэглэл, тайзны хэрэгсэл зэргийг худалдан авснаас шалтгаалжээ.

Оны эцэст 5,000.0 мянган төгрөгийн шатахууны худалдан авалт хийж бараа материалд үлдэгдлээр тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 25-ны А-4/188, 2019 оны 10 дугаар сарын 28-ны А-1/372 тоот шийдвэрээр 47,621.9 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, 37,360.1 мянган төгрөгөөр тавилга худалдан авснаас шалтгаалжээ. ТӨБЗГ-ын 2019 оны 05 дугаар сарын 10-ны А-5/1279 тоот шийдвэрээр 77 нэр төрлийн 18,316.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,739,994.7 мянган төгрөг болж 241,222.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх соёл урлагийн хөтөлбөрт зориулан 2,543,303.7 мянган төгрөгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсвийн санхүүжилт 2,543,303.7 мянган төгрөгийн төсвөөс 2,537,573.5 мянган төгрөгийг зарцуулж 5,730.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь тэтгэвэрт гарах ажилтан чөлөөлөгдөөгүй, туслах үйл ажиллагааны орлого 1,819.8 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна. Төсвийн санхүүжилтээр 200,000.0 мянган төгрөгөөр бүтээх “Марко Поло” хэмээх шинэ уран бүтээл хийгдсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 604,312.7 мянга, туслах үйл ажиллагааны 1,819.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн бөгөөд энэ нь тайлант онд тэмдэглэлт ой, баяр ёслолоор болон бусад үйл ажиллагаанд зориулан 135 тоглолт хийсэн, шинээр 3 уран бүтээл туурвисан тоглолтын орлого байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 604,312.7 мянган төгрөгөөр нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 300,000.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 180,000.0 мянга, урамшуулалт цалинд 78,600.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 10,000.0 мянга, хангамж бараа материалын зардалд 5,450,0 мянга, эд хогшил тавилга худалдан авахад 29,697.9 мянга, гадаад албан томилолтын зардалд 564.8 мянган төгрөг буюу нийт 604,312.7 мянган төгрөгийг Сангийн сайдын 2019 оны “Төсвийн зарлагын хэмнэлт буюу үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” батлах тухай 74 дүгээр тушаалыг үндэслэн Үндэсний урлагийн их театрын захирлын 2019 оны 08 дугаар сарын 14-ий өдрийн А/28 тоот, 2019 оны 12 дугаар сарын 09-ий өдрийн А/46 тоот, 12 дугаар сарын 23-ны өдрийн А/53 тоот, 12 дугаар сарын 25-ны А/55 тоот тушаалаар зарцуулсан байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 26 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 29,957.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3,324.9 мянган төгрөгийн 4 акт тогтоож, 24,333.3 мянган төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлж, 2,299.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 27,658.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 7 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Туршилтын хугацаанд ажилласан ажилтанд 562.3 мянган төгрөгийн нэмэгдэл, урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-т “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Туршилтын хугацаанд ажилласан ажилтанд олгосон нэмэгдэл урамшуулал олгосныг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох

2. Автомашины 100 км-т зарцуулалтын норм баримтлаагүй, 185.7 мянган төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан нь Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 тоот тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн

Нормоос илүү зарцуулсан 185.7 мянган төгрөгийн шатахууны үнийг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

3. Албан хаагчдад цалин, амралтын цалинг давхардуулан 2,426.1 мянган төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Эрүүл Мэндийн Сайд, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2000 оны 166 тоот тушаалын 19 дүгээр зүйлийн 1.3-т "ажил олгогч нь бүх ажилтанг жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлүүлэх бололцоогоор хангаж эдлүүлнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2-т "ажилтанд ээлжийн амралтын хугацаанд нь ээлжийн амралтын олговор олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ажиллагсдад цалин, амралтын цалинтай давхардуулан олгосныг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох

4.Үндэсний урлагийн их театрын захирлын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Б/106 тоот тушаалаар сахилгын шийтгэлтэй ажилтны цалингаас 149.5 мянган төгрөгийн суутгал хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Сахилгын шийтгэлтэй ажилтны цалингаас дутуу суутгасан цалинг суутгаж, төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

5. Төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтныг төрийн албанд дахин томилон ажиллуулж, 12,574.3 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл хөлс олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4-т "үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэсэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтанд цалингийн нэмэгдэл хөлс олгохыг таслан зогсоох албан шаардлага өгөх.

6. Байгууллагын удирдлага нь театрын тайзны гэрэлтүүлгийн сэлбэг, туслах хэрэгсэл нийлүүлэхээр байгууллагын хамаарал бүхий ажилтантай гэрээ байгуулж, 9,800.0 мянган төгрөгийг нэгжийн дарга Х.Энхбатын хувийн дансанд шилжүүлсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Байгууллагын удирдлага бараа үйлчилгээ худалдан авах, бүтээгдэхүүн нийлүүлэхээр байгууллагын хамаарал бүхий ажилтантай гэрээ байгуулах үйл ажиллагааг таслан зогсоох албан шаардлага өгөх.

7. Захирлын тушаалаар ажиллагсдад нэмэгдэл урамшуулал олгохдоо хуулийн хүрээнд байгууллагын хамт олны ажлын үр дүнг харгалзахгүйгээр хавтгайруулан олгосон нь Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 238 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.10.1-т “Байгууллагын хамт олныг ажлын үр дүнг харгалзан урамшуулна” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шагнал урамшууллыг Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолын 6 дугаар хавсралтын дагуу ажил дүгнэсэн үзүүлэлтээр олгож, санхүүжилтийг бодитой тодорхойлж, төсвийг үр ашигтай удирдан, гүйцэтгэлийг хангаж ажиллах албан шаардлага өгөх.

8. Ваучерийн тооцоог аккруэл сууриар хөтлөөгүй, харилцагч бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ваучерийн тооцоог аккруэл сууриар хөтлөж, харилцагч бүрээр анхан шатны баримтыг үндэслэн тайлагнаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж хэвших албан шаардлага өгөх.

9. Зардлын зүйл анги зөрчин цалингийн зардлаас ажилчдад нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгосон нь Сангийн сайдын 2014 оны “Эдийн засгийн ангилал батлах тухай” 05 тоот тушаалын 02 дугаар хавсралтад “төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Батлагдсан төсвийн хүрээнд эдийн засгийн ангиллын дагуу зардал гаргаж байх албан шаардлага өгөх.

10. Тайлант хугацааны эцэст 5,000.0 мянган төгрөгийн шатахууны их хэмжээний худалдан авалт хийж, илүү нөөцөлж, үлдэгдлээр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Санхүүжилтийг бодитой тодорхойлж, төсвийг үр ашигтай, удирдан, гүйцэтгэлийг хангаж ажиллах албан шаардлага өгөх.

11. Түр хугацаагаар гэрээт ажилтнаар авч ажиллуулсан оюутнуудад 420.7 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн 2,299.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Үндэсний урлагын их театрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны аудитын шийдвэрийн хэрэгжилтийг нарийвчлан шалгах шаардлагатай. Үндсэн үйл ажиллагааны орлогыг 2020 оны батлагдсан төсөвт тусгаагүй байгаа тул гол анхаарах асуудлаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Үндэсний урлагийн их театр Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 49 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7,820.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна.

Нийт 8 зөвлөмж өгснөөс 7 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд, зөвлөмжийн хэрэгжилт 87.5 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үндэсний урлагийн их театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй 27,658.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийн дүн бидний тогтоосон материаллаг байдлын төвшин 58,206.1 мянган төгрөгөөс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Үндэсний урлагын их театрын 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсгийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууриас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалин хөлсийг бодож олгохдоо анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангагдахгүй байх, хууль зөрчигдөх, төсвийг үр ашиггүй зарцуулах

1.3. Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналт, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллана.

Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, хууль тогтоомж хэрэгжихгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Тухайн байгууллагын өөрийн онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шатандаа байгаа талаар хариу ирүүлсэн.

Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын шимтгэлийг зөрүүтэй тооцоолж, 2,299.1 мянган төгрөгийг илүү төлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Байгууллагын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.3- т “Харилцагч байгууллага, хувь хүн болон татвар, нийгмийн даатгалын байгууллагуудтай тооцоо нийлж өр, авлага үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй удирдаж, үр ашиггүй зарцуулснаас өр авлага үүсэх

3.3. Өгсөн зөвлөмж:

Ажил, гүйлгээг гарахаас нь өмнө дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулж, дотоод хяналт, санхүүгийн хариуцлагыг сайжруулан ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2020 оны 1 дүгээр сарын нийгмийн даатгалын тайланд суутган тооцсон.

Дотоод хяналттай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй автомашиныг зогсоолгүй гэсэн шалтгаанаар ажлын бус цагаар жолооч ашиглаж байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.1.4-т “эд хариуцагч биш боловч эрхэлсэн ажилтай нь холбогдуулан өөрт нь бүрэн хариуцуулахаар олгосон ажлын багаж, хамгаалах хэрэгсэл, тусгай хувцас зэрэг эд хөрөнгийг үрэгдүүлсэн”, 135.3-т “Ажил олгогч нь эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэж болох ажил, албан тушаалын жагсаалтын дагуу ажилтантай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай гэрээ байгуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл:

Хөрөнгө зориулалт бусаар ашиглагдах, эзэнгүйдэх

4.3. Өгсөн зөвлөмж

Ажил олгогч нь ажилтантай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж ажиллах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хөрөнгө эзэмшигчтэй эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж ажиллана.

Балансын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээс Бүгд Найрамдах Солонгос Улсын "Экспорт-Импорт банк"-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа "Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл"-ийн хүрээнд нийлүүлсэн том оврын автобусыг тус байгууллагад хуваарилсныг данс бүртгэлд тусгаагүй байна.

5.2. Эрсдэл:

Хөрөнгө эзэнгүйдэх

5.3. Өгсөн зөвлөмж:

Авто тээврийн хэрэгслийг данс бүртгэлд тусгах

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Хөрөнгийг данс бүртгэлд тусгана.

6. Орлогын данстай холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2019 онд үндсэн үйл ажиллагааны орлогын батлагдсан төлөвлөгөөгүй 604,312.7 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлсэн нь Сангийн сайдын 2019 оны "Төсвийн зарлагын хэмнэлт буюу үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам" батлах тухай 74 дүгээр тушаалын 3.4.3-т "Үндсэн үйл ажиллагааны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

6.2 Эрсдэл:

Хууль зөрчигдөх, орлого бүрдүүлэх боломж алдагдах

6.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн үйл ажиллагааны орлогыг батлуулж ажиллах

6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,165,994,698.11	1,435,507,440.33
33	АВЛАГА	5,395,050.61	5,869,948.37
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	206,687.20	238,950.00
335	Бусад авлага	5,188,363.41	5,630,998.37
3351	Байгууллагаас авах авлага	64,261.06	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,124,102.35	5,630,998.37
35	БАРАА МАТЕРИАЛ	1,160,599,647.50	1,429,637,491.96
351	Түүхий эд материал	951,518,910.39	1,199,279,750.99
35110	Тусгай зориулалттай материал	951,518,910.39	1,199,279,750.99
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,245,970.32	4,143,561.44
354	Хангамжийн материал	204,834,766.79	226,214,179.53
35420	Аж ахуйн материал	202,834,766.79	221,214,179.53
35440	Түлш, шатах тослох материал	2,000,000.00	5,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	332,780,825.06	304,487,240.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	332,780,825.06	304,487,240.14
392	Биет хөрөнгө	332,780,825.06	304,487,240.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	213,347,827.25	213,347,827.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	166,664,898.59	190,260,798.09
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	281,781,363.79	327,317,343.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	216,267,692.47	240,355,632.43
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	213,352,713.67	230,755,850.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	171,505,911.08	163,310,433.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	673,696,851.73	677,422,851.73
39215	Хуримтлагдсан элэгдэл	494,959,429.24	550,429,769.49
39301	Програм хангамж	1,488,750.00	1,488,750.00
